



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хутаг-Өндөр сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/110/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Булган аймаг
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ

Утас: **7034-2580**

Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: **7034-2716**

Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

ЦЭСБ аудит ХХК-ийн захирал: Ч.Цэрэннадмид

Утас: **9511-2689**

Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Аудитор Ш.Ганчимэг

Утас: **99377360**

Цахим хаяг: shagdarganchimeg44@jmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	1-2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11-14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	11-14
4. Аудитын тайлан.....	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16 -17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ

С.МӨНХЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хутаг-Өндөр сумын цэцэрлэгийн 2022 оны зардлыг улсын төсвөөс 706,668.0 мянга, орон нутгийн тусвөөс төсвөөс 111,166.7 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталснаас нийт зардлын гүйцэтгэл 97.1 хувьтай хэрэгжжээ.

Тус цэцэрлэг нь 2020 онд үүссэн “Битач” ХХК-аас авах хүүхдийн тоглоомын үлдэгдэл 7600.0 мянган төгрөгийн авлагыг тайлант онд бүрэн барагдуулсан байна.

Аудитын гол асуудал

Тус цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан сумын Засаг даргаар батлуулж ажиллажээ. Хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 6 зорилтын 49 ажил, арга хэмжээг зохион байгуулан хэрэгжүүлж, гүйцэтгэлийг 98 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>24,382,144.35</u>	<u>52,461,392.68</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	14,910,796.20
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	14,910,796.20
31211	Төрийн сангийн харилцах	00.00	14,910,796.20
33	АВЛАГА	7,600,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	7,600,000.00	00.00
354	Хангамжийн материал	16,782,144.35	37,550,596.48
35410	Бичиг хэргийн материал	310,000.00	96,500.00
35420	Аж ахуйн материал	8,980,000.00	11,179,000.00
35440	Түлш, шатах тослох материал	3,348,125.00	4,489,000.00
35460	Хүнсний материал	4,144,019.35	21,786,096.48
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>637,414,987.59</u>	<u>622,350,141.14</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	637,414,987.59	622,350,141.14
392	Биет хөрөнгө	607,544,987.54	592,480,141.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	747,647,995.20	747,558,995.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	(252,587,809.92)	(274,771,321.92)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	75,993,486.55	78,031,930.45
39206	Хуримтлагдсан элэгдэл	(31,796,706.01)	(25,621,142.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,595,570.20	42,822,621.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,470,395.91)	(11,427,569.21)
39214	Бусад үндсэн хөрөнгө	67,955,839.50	55,816,721.10
39215	Хуримтлагдсан элэгдэл	(33,323,809.46)	(23,152,191.19)
39217	Ном	1,530,817.39	1,530,817.39
393	Биет бус хөрөнгө	29,870,000.05	29,870,000.05
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(109,999.95)	(109,999.95)
39303	Бусад биет бус хөрөнгө	29,100,000.00	29,100,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>661,797,131.94</u>	<u>674,811,533.82</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>1,060,742.25</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,060,742.25
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,060,742.25
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>661,797,131.94</u>	<u>673,750,791.57</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	661,797,131.94	673,750,791.57
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	531,559,751.60	531,559,751.60
51101	Өмч: - төрийн	531,559,751.60	531,559,751.60
512	Хуримтлагдсан үр дүн	(209,630,872.51)	(218,825,278.78)
51210	Өмнөх үеийн үр дүн	(209,630,872.51)	(208,339,247.51)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(10,486,031.27)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	339,868,252.85	361,016,318.75
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>661,797,131.94</u>	<u>674,811,533.82</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	727,657,933.00	823,069,300.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	726,977,933.00	823,069,300.78
120	Нийтлэг татварын бус орлого	32,624,370.00	7,894,130.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	32,624,370.00	7,894,130.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	20,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	32,624,370.00	7,874,130.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	694,353,563.00	815,175,170.78
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	643,875,300.00	706,668,000.00
123004	Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг	50,478,263.00	108,507,170.78
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	680,000.00	00.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	360,000.00	00.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	360,000.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	320,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	260,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	60,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	729,993,115.99	833,555,332.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	729,993,115.99	833,555,332.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	684,675,593.52	818,300,531.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	481,124,814.00	538,915,710.18
210101	Үндсэн цалин	346,840,626.00	392,635,321.18
210102	Нэмэгдэл	86,686,877.00	120,863,441.00
210104	Урамшуулал	47,597,311.00	25,416,948.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,277,018.03	67,468,621.00
210201	Тэтгэврийн даатгал	43,635,932.18	45,981,478.28
210202	Тэтгэмжийн даатгал	4,829,754.04	5,409,585.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,863,803.33	4,287,348.54
210204	Ажилгүйдлийн даатгал	904,321.51	1,071,837.14
210205	Эрүүл мэндийн даатгал	9,043,206.97	10,718,371.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,377,638.00	52,962,734.22
210301	Гэрэл, цахилгаан	5,765,863.00	9,391,184.22
210302	Түлш, халаалт	42,537,775.00	43,435,550.00
210303	Цэвэр, бохир ус	74,000.00	136,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,193,960.00	00.00
210401	Бичиг хэрэг	634,950.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	1,214,200.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	641,080.00	00.00
210404	Ном, хэвлэл	27,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	917,500.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,759,230.00	00.00
2105	Нормативт зардал	25,131,264.15	80,232,578.67

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	126,350.00	00.00
210502	Хоол, хүнс	23,789,914.15	80,232,578.67
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,215,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,321,100.00	2,293,400.00
210604	Урсгал засвар	1,321,100.00	2,293,400.00
2107	Томилолт, зочны зардал	193,200.00	00.00
210702	Дотоод албан томилолт	193,200.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,388,208.00	1,255,214.07
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,388,208.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,255,214.07
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,668,391.34	75,172,273.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,701,500.00	16,735,206.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,629,350.00	6,303,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	52,337,541.34	52,133,167.35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,317,522.47	15,254,800.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	894,000.00	6,633,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	894,000.00	6,633,100.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,423,522.47	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,423,522.47	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	8,621,700.56
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	8,621,700.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(2,335,182.99)	(10,486,031.27)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	40,882,215.27	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	7,455,555.52	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	33,426,659.75	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(40,882,215.27)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(43,217,398.26)	(10,486,031.27)

Булган аймаг дахь Төрийн аудитын газар

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	699,883,417.50	815,195,170.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	698,843,417.50	815,195,170.78
120	Нийтлэг татварын бус орлого	4,489,854.50	20,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,489,854.50	20,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,489,854.50	20,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	694,353,563.00	815,175,170.78
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	643,875,300.00	706,668,000.00
123004	Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг	50,478,263.00	108,507,170.78
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,040,000.00	00.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	720,000.00	00.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	720,000.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	320,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	260,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	60,000.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	676,036,417.50	795,322,474.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	676,036,417.50	795,322,474.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	630,718,895.03	780,067,674.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	481,124,814.00	537,854,967.93
210101	Үндсэн цалин	346,840,626.00	391,574,578.93
210102	Нэмэгдэл	86,686,877.00	120,863,441.00
210104	Урамшуулал	47,597,311.00	25,416,948.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,277,018.03	67,468,621.00
210201	Тэтгэврийн даатгал	43,635,932.18	45,981,478.28
210202	Тэтгэмжийн даатгал	4,829,754.04	5,409,585.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,863,803.33	4,287,348.54
210204	Ажилгүйдлийн даатгал	904,321.51	1,071,837.14
210205	Эрүүл мэндийн даатгал	9,043,206.97	10,718,371.36
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,278,263.00	54,183,609.22
210301	Гэрэл, цахилгаан	5,765,863.00	9,391,184.22
210302	Түлш, халаалт	43,438,400.00	44,656,425.00
210303	Цэвэр, бохир ус	74,000.00	136,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,937,380.00	00.00
210401	Бичиг хэрэг	560,000.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	1,029,200.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	481,080.00	00.00
210404	Ном, хэвлэл	35,950.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,760,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,071,150.00	00.00

2105	Нормативт зардал	22,653,162.00	97,874,655.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	126,200.00	00.00
210502	Хоол, хүнс	21,306,962.00	97,874,655.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,220,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,000.00	2,692,400.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	2,692,400.00
2107	Томилолт, зочны зардал	193,200.00	00.00
210702	Дотоод албан томилолт	193,200.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,388,208.00	1,255,214.07
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,388,208.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,255,214.07
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,666,850.00	18,738,206.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,394,000.00	11,286,409.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,272,850.00	7,451,797.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,317,522.47	15,254,800.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	894,000.00	6,633,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	894,000.00	6,633,100.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,423,522.47	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,423,522.47	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	8,621,700.56
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	8,621,700.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	23,847,000.00	19,872,696.20
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	24,057,000.00	4,961,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,057,000.00	4,961,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	24,057,000.00	4,961,900.00
222001	Тоног төхөөрөмж	23,963,000.00	4,961,900.00
223001	Бусад хөрөнгө	94,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(24,057,000.00)	(4,961,900.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(210,000.00)	14,910,796.20
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	210,000.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	14,910,796.20

Булган аймаг дахь Төрийн аудитын газар

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	531,559,751.60	339,868,252.85	(153,897,503.49)	717,530,500.96
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	531,559,751.60	339,868,252.85	(153,897,503.49)	717,530,500.96
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	18,548,192.85	18,548,192.85
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	531,559,751.60	339,868,252.85	(209,630,872.51)	661,797,131.94
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	531,559,751.60	339,868,252.85	(209,630,872.51)	661,797,131.94
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,291,625.00	1,291,625.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	531,559,751.60	339,868,252.85	(208,339,247.51)	663,088,756.94
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	21,148,065.90	-	21,148,065.90
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(10,486,031.27)	(10,486,031.27)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	531,559,751.60	361,016,318.75	(218,825,278.78)	673,750,791.57

Булган аймаг дахь Төрийн аудитын газар

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	817,834,700.00	800,284,374.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	811,201,600.00	785,029,574.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	811,201,600.00	785,029,574.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	540,894,000.00	537,854,967.93
210101	Үндсэн цалин	434,147,500.00	391,574,578.93
210102	Нэмэгдэл	90,392,200.00	120,863,441.00
210104	Урамшуулал	16,354,300.00	25,416,948.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,319,000.00	67,468,621.00
210201	Тэтгэврийн даатгал	46,558,600.00	45,981,478.28
210202	Тэтгэмжийн даатгал	5,449,000.00	5,409,585.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,349,100.00	4,287,348.54
210204	Ажилгүйдлийн даатгал	1,088,600.00	1,071,837.14
210205	Эрүүл мэндийн даатгал	10,873,700.00	10,718,371.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,457,100.00	54,183,609.22
210301	Гэрэл, цахилгаан	13,509,700.00	9,391,184.22
210302	Түлш, халаалт	51,147,400.00	44,656,425.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	136,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	00.00
210401	Бичиг хэрэг	00.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	00.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	00.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
2105	Нормативт зардал	107,995,800.00	97,874,655.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	
210502	Хоол, хүнс	107,995,800.00	97,874,655.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,700,000.00	2,692,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	00.00
210604	Урсгал засвар	2,700,000.00	2,692,400.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	
210702	Дотоод албан томилолт	00.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,628,000.00	1,255,214.07
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,628,000.00	1,255,214.07
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,207,700.00	23,700,106.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,647,700.00	16,248,309.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,560,000.00	7,451,797.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,633,100.00	15,254,800.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,633,100.00	15,254,800.56
213202	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	8,621,700.56
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,663,100.00	6,633,100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	817,834,700.00	815,195,170.78
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	706,668,000.00	706,668,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	706,668,000.00	706,668,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	111,166,700.00	108,507,170.78
132001	Орон нутгийн төсвөөс	111,166,700.00	108,507,170.78
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	20,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	20,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	14,910,796.20

Булган аймаг дахь Төрийн аудитын газар

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Хутаг-Өндөр сумын цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох чиг үүрэгтэй, Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант онд “Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад “Шинэ багш”, “Шинэ ирээдүй” дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах” гэсэн зорилго дэвшүүлжээ. Энэхүү зорилгыг хангах чиглэлээр 10 зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Цэцэрлэгийн хүчин чадлаарх хүүхдийн тоо 250, гүйцэтгэлээр үндсэн 10 бүлэгт 296, хувилбарт сургалтад 112 хүүхэд хамрагдаж, хамран сургалт 95.5 хувьтай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Боловсролын тухай хууль, СӨБ-ийн тухай хууль, Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 107,192-р тогтоол, 107 БШУС-ын 2022 оны А/500, А/494, А/430, А/122 дугаар тушаал, Боловсролын ерөнхий газрын 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 1/1649 дугаар албан бичгээр ирүүлсэн заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна. Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 захирамжаар баталсан Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Энэ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Хутаг-Өндөр сумын цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,014.4 мянган төгрөгөөр буюу 1.95 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	14,910.8	14,910.8
Хувь хүнээс авах авлага	7,600.0		(7,600.0)
Бараа материал	16,782.1	37,550.6	20,768.5
Үндсэн хөрөнгө	637,415.0	622,350.1	(15,064.8)
Нийт хөрөнгө	661,797.1	674,811.5	13,014.4
Өр төлбөр		1,060.7	1,060.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	661,797.1	673,750.8	11,953.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	661,797.1	674,811.5	13,014.4

Тайлант онд бараа үйлчилгээний авлагыг 7,600.0 мянган төгрөгийг бүрэн барагдуулж, үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 37,550.6 мянган төгрөг болж 20,768.5 мянган төгрөгөөр өссөн нь хүүхдийн хүнсэнд хэрэглэх махыг 5 сар хүртэл нөөцөлснөөс шалтгаалсан байна. Мөн 2020 онд үүссэн тоглоомын авлагыг барагдуулж зарцуулаагүй үлдэгдлийг аж ахуй материалд бүртгэсэн.

Төсвийн хөрөнгөөр 120,859.0 мянга, авлагаар 5,144.0 мянга, хандив тусламжаар 663.4 мянган төгрөгийн бараа материал авч, тайлант хугацаанд 105,898.0 мянган төгрөгийн материалыг зарцуулан, 37,550.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна. Үүнээс 21,786.0 мянган төгрөг буюу 58 хувь нь хүнсний материал, 11,179.0 мянга буюу 29.7 хувийг нь аж ахуй материал эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны хувьд 7,417.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандив тусламжаар 7,210.7 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч, 40,415.8 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож, анхны үнээр нь бүртгэсэн байна. Мөн 8923.8 төгрөгийн хөрөнгө акталж, 52,133.1 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаар оны эцэст 622,350.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 673,750.8 мянган төгрөг болж 11,953.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой байна.

Байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 95,411.4 мянган төгрөгөөр буюу 13.1 хувиар өсөхөд тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 62,792.7 мянга, орон нутгийн төсвийн санхүүжилт 58,028.9 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.

Урсгал зардал өмнөх оноос 103,562.2 мянган төгрөгөөр өсчээ. Үүнээс хүүхдийн хоолны зардал 56,442.7 мянган төгрөгөөр буюу 3.4 дахин нэмэгдсэн нь өмнөх оны зарцуулалттай холбоотой байна.

3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,442,970.4 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 817,834.7 мянган төгрөгөөр баталж, 625,135.7 төгрөгөөр бууруулсан байна.

Хүснэгт 2: Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл /мян. төгрөг/

№	Төсвийн төрөл	Төсөвлөсөн	Батлагдсан төсөв	Зөрүү
1	Улсын төсөв	1,324,451.2	706,668.0	617,783.2
2	Орон нутгийн төсөв	118,519.2	111,166.7	7,352.5

Тус цэцэрлэгт 2022 онд ашиглалтанд орох төлөвлөгөөтэйгээр 2021 оноос 120 хүүхдийн шинэ цэцэрлэг баригдаж эхэлсэн бөгөөд төсвийн төсөлдөө шинэ цэцэрлэг ашиглалтанд орсноор нэмэгдэх орон тоо, түүний цалин хөлс, өдрийн ангид хичээллэх хүүхдийн тоо, шинэ барилгын тогтмол зардал зэргийг 2022 оны төсвийн төсөлд тусгасан байна. Тус барилга нь зах зээлийн үнийн өсөлтөөс төсвийн зөрүү гарч тус зөрүү нь улсын төсөвт тусгагдахгүй байгаагаас болоод одоог хүртэл ашиглалтанд ороогүй байна. Мөн Боловсролын тухай хуулийн дагуу хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан багш, ажилтанд олгодог нэг удаагийн тэтгэмж нь тухай байгууллагын төсвийн төлөвлөлтөнд ордог ч гүйцэтгэл нь Боловсрол, Шинжлэх Ухааны газарт хуваарилагддаг.

Мөн 2022 онд боловсролын салбарын төсвийн шинэчлэл хийгдсэнээр хангамж бараа материал, нормативт зардал /хоолноос бусад/, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал зэрэг зардлууд хасагдсан, нэг хүүхдийн хувьсах зардлын хэмжээ өөрчлөгдсөн зэрэг олон шалтгаан нь төсвийн төлөвлөлт болон батлагдсан төсвийн зөрүүнд нөлөөлсөн.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 706,668.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 111,166.7 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 817,834.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 14,910.8 мянган төгрөгийг зарцуулаагүй үлдэгдлээр тайлагнажээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 794,302.2 мянган төгрөг буюу 97.1 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 11,273.4 мянга, цалин 3,039.0 мянга, нормативт зардал /хоол/, 10,121.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Хөтөлбөр СӨБ- 78801	585,255.7	582,491.2	2,764.5	99.53
	Боловсролын стандарт 81834	492,431.9	490,585.8	1,846.1	99.6

	Сургалтын хэвийн үйл ажиллагаа 81835	98,444.2	95,827.3	2,616.9	97.3
	Эрүүл мэндийг дэмжих 81605	2,200.0	2,200.0	0.0	100
	Хүүхдийн хоол 81807	107,995.8	97,874.7	10,124.18	90.6
	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин 81816	3,396.1	3,396.1	0.0	100
	Боловсролын байгууллагын багш 81823	2,200.0	1,893.4	306.6	86.1
	81834	344,823.8	342,377.5	2,446.3	98.95
	81835	67,397.7	67,153.2	244.5	99.63

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрсөн орлого байхгүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хутаг-Өндөр сумын цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “ЦЭСБ аудит” ХХК-ийн аудитор Ш.Ганчимэг, аудиторын туслах Б.Бүжингоо нар гүйцэтгэж, хяналтыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Хутаг-Өндөр сумын цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 729,993.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,109.9 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэх үе шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ.

Энэ хуулийн хүрээнд батлагдсан төсөв 14,910.8 мянган төгрөгөөр зарцуулагдаагүй үлдсэн нь урсгал зардал 4,289.5 мянган төгрөгөөр хэмнэгдсэн ч хөрөнгө худалдан авахад 1,525.0 мянган төгрөг зарцуулсан нь нөлөөлсөн. Тайлант онд үндсэн цалин 32,377.6 мянган төгрөгөөр хэмнэгдэж, нэмэгдэл, урамшуулал 29,687.4 мянган төгрөгөөр хэтэрсэн нь төсвийн төлөвлөлттэй холбоотой байна.

Харин төсвийн хөрөнгөөр XXI зуун Монголын нэр бүлийн холбоо, Бөртэ гэр бүлийн хөгжлийг дэмжих төв төрийн бус байгууллагатай 1500.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан сургалт зохион байгуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т “Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилот болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газар хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,956.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,500.0 мянган төгрөгийн албан шаардлага, 2,456.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

5.2 Албан шаардлага

Тус цэцэрлэг нь XXI зуун Монголын гэр бүлийн холбоо, Бөртэ гэр бүлийн хөгжлийг дэмжих төв төрийн бус байгууллагатай 1500.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан сургалт зохион байгуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т “Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалттай нийцэхгүй байх тул албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Илрүүлэлт:

Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын мэргэжилтэн Т.Ганчимэг, Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаа эрхэлсэн орлогч дарга П.Бямбасүрэнтэй сургууль, цэцэрлэгийн багш ажилтныг эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамруулах тухай хамтран ажиллах гэрээ байгуулсан уг гэрээнд үзлэг оношилгооны нэр төрөл, үнэ, хэдэн ажилтан хамрагдах эсэх нь

тусгагдаагүй, гэрээг дүгнээгүй, үр дүн тодорхойгүй байхад үзлэг оношилгооны төлбөрийг батлагдсан төсвийн дүнгээр /2,200.0/ мянган төгрөгөөр төлсөн байна.

Энэ нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/238, А/340 дүгээр тушаалын 3.1, 3.2, БШУС-ын 2022 оны 07 дугаар сарын 22-ны А/259 дугаар тушаалаар баталсан “Цэцэрлэг, ЕБС-ийн багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношлогоонд хамруулах заавар”-ын 2.3, 2.5, 2.7.5 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид дээрх журам, зааврын дагуу эрүүл мэндийн үзлэг, оношилгоог зохион байгуулж ажиллах.

Илрүүлэлт:

Тайлант хугацааны хүүхдийн хоолны зардлын гүйцэтгэлд түүврийн сорил хэрэгжүүлэхэд 7, 12 дугаар сард хоолны зардлыг 256.8 мянган төгрөгөөр хэтрүүлсэн нь Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 450 дугаар тогтоолын 1-д Цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 2475 төгрөгөөр тогтоосныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор баталсан цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг мөрдөж ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс					Зөвлөмж	
						Залруулсан		Залруулаагүй				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эрүүл мэндийн нэмэлт үзлэг	1	2,200.0	-	-	-	-	1	2,200.0	-	-	-	-

